



SG INVESTMENT & SECURITIES

20
24

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН СУДАЛГАА

Дэлгэрэнгүй судалгаа

Агуулга


| | |
|---------------------------------------|-----------|
| Монгол улсын макро эдийн засаг | 01 |
| Экспорт ба импорт | 02 |
| Инфляцийн төлөв байдал | 03 |
| Төсөв | 04 |
| Засгийн газрын өр төлбөр | 05 |
| Мөнгөний нийлүүлэлт | 06 |
| Банк санхүүгийн зах зээл | 07 |
| Хөрөнгийн зах зээл | 08 |
| Дүгнэлт | 09 |

Монгол улсын макро эдийн засаг

Дотоодын нийт бүтээгдэхүүн

Эдийн засгийн өсөлт 2024 оны гуравдугаар улиралын байдлаар 5.0 хувь байна.

2024 оны эхний гурван улирлын эдийн засгийн өсөлтөд уул уурхай, үйлчилгээний салбарууд голлох үүрэг гүйцэтгэсэн боловч хөдөө аж ахуйн салбарын агшилт нь нийт өсөлтийг хязгаарлаж, салбар хоорондын харьцааг тэнцвэргүй болгосон байна.



Эдийн засгийн салбаруудын өсөлт



Уул уурхай: 1.4%-ийн өсөлттэй байна. Монгол Улсын эдийн засаг ихэнхдээ уул уурхайд түшиглэдэг учраас энэ салбарын өсөлт чухал нөлөөтэй.


Цэвэр тээвэр: 2.1%-ийн өсөлттэй, үйлчилгээний дараа орж байгаа бөгөөд тээврийн салбарын өсөлт, дэд бүтцийн сайжруулалтаас ихээхэн хамааралтай байна.

Хөдөө аж ахуй: -3.5%-ийн бууралттай, эдийн засагт сөрөг нөлөө үзүүлж байна. Хүндэрсэн цаг уурын нөхцөл, өвөлжилт, мал аж ахуйн салбарт гарсан хохирол зэрэг нь энэ салбарт хүндээр туссан.


Аж үйлдвэр, барилга: 0.3%-ийн өсөлттэй, харьцангуй бага өсөлттэй байгаа бөгөөд энэ нь дотоодын хөрөнгө оруулалт, барилгын материалын үнэ өссөнөөс хамаарч байна.

Үйлчилгээний салбар: 4.6%-ийн өсөлттэй, эдийн засагт хамгийн их хувь нэмэр оруулсан салбар байна.

Монгол Улсын зээлжих зэрэглэлийг 2024 оны 9 дүгээр сарын 18-ны өдөр "Fitch Ratings" агентлаг "B+, тогтвортой" болгож нэмэгдүүлсэн бол 2024 оны 10 дугаар сарын 04-ний өдөр "S&P Global" агентлаг "B+, эерэг" болгон ахиуллаа.



Уул уурхайн салбар







2024 оны эхний улирлуудад уул уурхайн салбарын өсөлт тогтмол үргэлжилж байгаа ч өсөлтийн хурд удааширч, гуравдугаар улиралд 11.4%-д хүрсэн байна. Нүүрсний экспорт 26%-иар өссөн нь салбарын өсөлтөд хамгийн их нөлөөлсөн хүчин зүйлүүдийн нэг юм.

Зэсийн баяжмалын үйлдвэрлэл 7.8%-иар өссөн нь уул уурхайн салбарын нийт өсөлтөд эерэгээр нөлөөлсөн. Оюутолгой болон бусад томоохон төслүүдийн үйл ажиллагаа тогтвортой явагдаж байгаа нь үүнд хувь нэмэр оруулжээ.

Олон улсын зах зээл дээр нүүрс, зэс, төмрийн хүдэр зэрэг голлох түүхий эдүүдийн үнэ тогтвортой өндөр түвшинд байсаар байна. Энэ нь Монголын уул уурхайн бүтээгдэхүүний экспортын орлого нэмэгдэх шалтгаан болжээ.


Он гарснаас хойш Монголбанк алт худалдан авах хэмжээгээ тогтмол нэмэгдүүлснээр 10-р сарын байдлаар 14,115.84 кг алт худалдан авсан байна.

2024 оны эхний 11 сарын байдлаар уул уурхайн бүтээгдэхүүн нийт экспортын 93 хувийг, тэр дундаа нүүрс болон зэсийн баяжмал дангаараа 80 хувийг бүрдүүлсэн байна.



Экспорт

Монгол Улс 2024 оны эхний 10 сард дэлхийн 73 оронд, 13.2 тэрбум ам.долларын бараа, бүтээгдэхүүн экспортолж, экспортын дүн өнгөрсөн оны мөн үеэс 733 сая ам.доллаароор буюу 5.9 хувиар өслөө. Экспортын өсөлтөд нүүрс болон төмрийн хүдрийн экспортын биет хэмжээ нэмэгдсэн, дэлхийн зах зээл дээрх алт, зэсийн үнэ өссөн зэрэг нь эерэг нөлөө үзүүллээ.



Голлох уул уурхайн бүтээгдэхүүн : Уул уурхайн бүтээгдэхүүн нийт экспортын 93 хувийг, тэр дундаа нүүрс болон зэсийн баяжмал дангаараа 76 хувийг бүрдүүлээ.


Нүүрс: Нүүрсний экспортын биет хэмжээ 2024 оны эхний 9 сард 61.2 сая тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 25 хувиар нэмэгдсэн байна.

БНХАУ-ын хойд хэсгийн эдийн засгийн өсөлт тогтвортой байж манай улсын гадаад эрэлтийг дэмжиж байгаагаас гадна хил орчмын тээвэр зохион байгуулалт сайжирч, хилийн голлох боомтуудад автомат удирдлагатай тээврийн хэрэгслүүд нэвтэрсэн нь эерэг нөлөө үзүүлсэн байна.

Зэсийн баяжмал: Оюутолгойн гүний уурхайн олборлолт эхэлсэнтэй холбоотойгоор зэсийн баяжмалын экспортын биет хэмжээ 1186 мянган тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 3 хувиар нэмэгдлээ.

Төмрийн хүдэр: Төмрийн хүдрийн олборлолт нэмэгдсэнтэй холбоотойгоор төмрийн хүдрийн экспортын биет хэмжээ 5,461 мянган тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 29 хувиар өссөн байна.

Алт: Алтны олборлолт болон худалдан авалт буурч, экспортын биет хэмжээ 9 тонн буюу өмнөх оны түвшинд байсан хэдий ч дэлхийн зах зээл дээрх алтны үнэ өссөнөөс шалтгаалан алтны экспортын орлого 20 хувиар өссөн байна.



2024 оны жилийн эцсийн төлөв


Гадаад худалдааны нийт бараа эргэлт 2024 оны жилийн эцэст 28.5 тэрбум ам.долларт хүрч, худалдааны тэнцэл 4.9 тэрбум ам.долларын ашигтай гарахаар төсөөлж байна. Оюутолгойн гүний уурхайн нөлөөгөөр 2024 онд зэсийн баяжмалын экспорт 1,560 мянган тоннд хүрч нэмэгдэхээр байна.

Түүнчлэн, хилийн боомтуудын дэд бүтцийг сайжруулах, тээвэр зохион байгуулалтыг оновчтой хийх, уул уурхайн бүтээгдэхүүний биржийн үйл ажиллагааг өргөтгөх зэрэг арга хэмжээнүүдийн үр дүнд нүүрсний экспорт 78 сая тоннд, төмрийн хүдрийн экспорт 8,400 мянган тоннд, газрын тосны экспорт 4,210 мянган баррельд тус тус хүрч, нийт экспортын дүн 16.7 тэрбум ам.долларт хүрэх төлөвтэй байна.

Импорт

Импортын нийт хэмжээ:

2020-2024 оны 10-р сарын байдлаарх импортын нийт хэмжээ тасралтгүй өссөн бөгөөд 2023 оны 10-р сард импортын хэмжээ 12474 сая ам.доллар байсан бол 2024 оны 10-р сард 13207 сая.ам доллар болж нэмэгдсэн байна.



Голлох бүтээгдэхүүнүүдийн импорт:


Барилгын материал: Барилгын материалын импортын зардал 2023 оны 10-р сард 987 сая ам.доллар байсан бол 2024 оны 10-р сард 1137 сая ам.доллар болж нэмэгдсэн байна. Монгол Улсад барилгын салбарын идэвхжил 2024 онд өндөр хэвээр байна. Барилгын салбарын идэвхжил ихтэй үед барилгын материалын эрэлт нэмэгдэж, үүний дагуу импортын зардал өссөн.

Хүнс: Монгол улсын хүнсний импорт 2024 оны 10 сард 953 сая ам доллар болж өмнөх оноос 179 сая ам.доллараар өссөн байна. Олон улсын зах зээлд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний үнэ өссөн нь импортын өртгийг нэмэгдүүлдэг. Сүүлийн жилүүдэд хөдөө аж ахуй, мал аж ахуйн бүтээгдэхүүний үнэ хоёр хөршийн улс төрөөс шалтгаалан (ОХУ болон Украин дайн, БНХАУ болон АНУ эдийн засгийн дайн) өргөн хэрэглээний үнэ өссөн

Суудлын авто машин: Монгол улсын суудлын автомашины импорт өмнөх оноос 333 сая.ам доллараар өссөн байна. Сүүлийн жилүүдэд цахилгаан болон илүү дэвшилтэт, шатахуун зарцуулалт багатай автомашинуудын эрэлт өссөн. Валютын ханшийн хэлбэлзлээс шалтгаалан импортын автомашины өртөг нэмэгдэх гол шалтгаан болсон.

Тоног төхөөрөмж: Монгол Улсын тоног төхөөрөмжийн импортын хэмжээ 1354 сая ам.доллараас 1817 сая ам.доллар болж, 463 нэгжээр өссөн. Эдийн засгийн зарим салбар, ялангуяа уул уурхай, барилга, дэд бүтэц зэрэг салбаруудын үйл ажиллагаа өргөжиж байгаа нь тоног төхөөрөмжийн эрэлтийг нэмэгдүүлж байна.

Шатахуун: Монгол Улсын шатахууны импортын хэмжээ 1289 сая ам.доллараас 1591 сая ам.доллар болж, 302 сая ам.долларар өссөн. Монголын эдийн засгийн өсөлт болон үйлдвэрлэл, тээвэр ложистикийн эрэлтийн өсөлт нь шатахууны хэрэглээг нэмэгдүүлж байна.




2024 оны жилийн эцсийн төлөв

2024 оны жилийн эцсийн байдлаар импортын хэмжээ 11.5 тэрбум ам.долларт хүрэх төлөвтэй байна. Энэ нь эдийн засгийн өсөлт, дотоодын эрэлт нэмэгдэж байгаагийн илрэл бөгөөд гадаад худалдааны тэнцэлд нөлөөлөх чухал хүчин зүйл болж байна.

Инфляци төлөв байдал

2023 оны сүүлчийн байдлаар инфляц 7.9 хувьд хүрч, тогтворжиж эхэлсэн нь Монголбанкны зорилтот түвшинд ойртож буй эерэг дохио юм. Гэсэн хэдий ч 2024 оны эхэн үеэс инфляц 8.1 хувь болсон нь бага зэрэг зорилтоос давсан үзүүлэлт юм.



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Монголбанкны инфляцийн зорилтот түвшин 2024 онд 6 ± 2 хувь байхаар тогтоогдсон бөгөөд энэ нь дунд хугацаанд эдийн засгийн тогтвортой байдлыг хангаж, иргэдийн худалдан авах чадварыг хадгалах үндсэн зорилготой юм.


“6” үндсэн чиглэл

- Гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх
- Экспортын бүтцийг төрөлжүүлэх
- Инфляцийг тогтворжуулах
- Зээл олголтыг зорилтот салбарт чиглүүлэх
- Санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах
- Хадгаламжийн хуримтлалыг нэмэгдүүлэх

“2” нэмэлт чиглэл


- Цахим шилжилтийг хурдасгах
- Тогтвортой санхүүжилт (ESG)

Засгийн газрын зардлын бодлого: Төсвийн зардал, тухайлбал, нийгмийн халамжийн болон дэмжлэгийн зардал нэмэгдсэн нь зах зээл дээрх мөнгөний эрэлтийг өсгөж, энэ нь инфляцийг нэмэгдүүлэхэд нөлөөлж байна



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2024 оны эхний улиралд сарын инфляци тогтвортой буурч байсан ч 4-р сараас эхлэн огцом 1.7%-ийн өсөлт үзүүлсэн байна. Монголбанк инфляцийн энэ огцом өсөлтийг түр зуурын хүчин зүйл гэж үзэн, бодлогын хүүг 10%-д тогтвортой хадгалах замаар инфляцийг тогтоон барих арга хэмжээ авсан.




Хувиар

Төсөв

Төсвийн орлого


2023 оны 3-р улирлын байдлаар ОАТ 4.9 их наяд байсан бол энэ оны 3-р улирлын байдлаар 7.3 их наяд болж 48.98%-иар өссөн. Энэ нь уул уурхайн салбарын өсөлтөөс шууд хамааралтай бөгөөд нүүрс, төмрийн хүдэр, зэс зэрэг бүтээгдэхүүний экспортын орлогын өсөлт нөлөөлсөн. НӨАТ 2023 оны байдлаар 3.8 их наяд байсан бол энэ оны 3-р улирлын байдлаар 4.6 их наяд болж 21.05%-иар өссөн. Нийгмийн даатгалын орлого 2023 оны 3-р улирлын байдлаар 3.1 их наяд байсан бол энэ оны 3-р улирлын байдлаар 3.8 их наяд болж 22.58%-иар өссөн. Энэ нь эдийн засгийн сэргэлттэй уялдаж байна. Бусад орлого 2023 оны байдлаар 4.3 их наяд байсан бол энэ оны 3-р улирлын байдлаар 6.4 их наяд болж 48.84%-иар өссөн бол АМНАТ энэ оны 3-р улирлын байдлаар 8.33%-иар буурсан үзүүлэлттэй байна. Энэ нь ашигт малтмалын зарим бүтээгдэхүүний олборлолт, борлуулалтын хэмжээнд гарсан сааталтай холбоотой. Тухайлбал, газрын тосны үйлдвэрлэлийн бууралт нөлөөлсөн.



Эх сурвалж: Сангийн яам

Төсвийн зардал

Монгол улсын 2024 оны нийт зардал 10 сарын байдлаар 22.3 их наяд төгрөг байна. Энэ нь өмнөх оны 10 сарын байдалтай харьцуулахад 8.3 их наядар буюу 59.76% өссөн байна: Төсвийн зардалд хамгийн их хувь эзлэж буй зардлуудыг дараах байдлаар харуулав. Үүнд




Эх сурвалж: Сангийн яам

- Нийгмийн даатгалын (НД) тэтгэврийн өсөлт (31.25%)
- Цалин хөлсний огцом өсөлт (127.78%)
- Барилга байгууламжийн зарлагын өсөлт (26.09%)
- Нийгмийн халамжийн (НХ) тэтгэврийн бага өсөлт (5.56%)
- Хүүгийн төлбөрийн бага өсөлт (10.00%)

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд оруулсан өөрчлөлтөөр Монгол Улсын хөгжлийн тулгамдсан асуудал, эдийн засгийн суурийг тэлэх эрчим хүч, дэд бүтэц, аж үйлдвэржилтийн томоохон төслүүдийг эхлүүлэхээр төлөвлөж, 2024 оны төсвийн хөрөнгө оруулалтын зардлыг 1.8 их наяд төгрөгөөр нэмэгдүүлээд байна.

Тэнцвэржүүлсэн тэнцэл

2020-2024 оны хооронд орлого, тусламжийн дүн 8.3 их наяд төгрөгөөс 25.5 их наяд төгрөг болж, 3 дахин нэмэгдсэн.




2020-2022 онуудад төсөв алдагдалтай байсан ч 2023 онд 2.1 их наяд төгрөгийн ашигтай гарсан. 2024 онд ашиг 1.5 их наяд төгрөг болж буурсан.

Орлогын огцом өсөлт нь дараах хүчин зүйлсээс шалтгаалсан:

- Уул уурхайн салбарын бүтээгдэхүүний үнэ дэлхийн зах зээл дээр өссөн.
 - Нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ)-ын орлого нэмэгдсэн.
 - Дотоодын эдийн засгийн идэвхжил сайжирч, хэрэглээ нэмэгдсэн.
 - Засгийн газрын татварын бааз өргөжиж, хяналт сайжирсан.
- Монгол Улс 2011 онд анх удаа Тэнцвэржүүлсэн тэнцлийн хуулийг баталж, төсвийн сахилга батыг сайжруулах алхам хийсэн.
 - 2023 онд тэнцвэржүүлсэн тэнцэлд суурилсан хөтөлбөрийн хүрээнд төсвийн алдагдлыг бууруулах зорилгоор зардлыг 15%-иар хязгаарлах бодлого хэрэгжүүлсэн.
 - Монгол улсын 2025 оны төсөв 33.5 их наяд буюу ДНБ-ий 35.2%-тай тэнцэж алдагдалгүй баталсан.


Засгийн газрын өр төлбөр



Засгийн газрын өр 2024 оны III улирлын байдлаар 30.8 их наяд буюу ДНБ-ий 38.9% эзлэж байгаа нь хуульд заасан тусгай шаардлагыг хангаж байна.



Олон улсын зах зээлд 2020 оноос хойш арилжаалсан Номад, Сенчири-2027, Сенчири-2028, Сенчири-2029, Сенчири-2031 үнэт цааснуудыг зөвхөн өрийг дахин санхүүжүүлэх зорилгоор гаргасан байна. Сенчири өрийн зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлснээр 2022-2024 онд төлөгдөх хуваарьтай байсан Чингис, Гэрэгэ, Хуралдай бондуудын нийт 2,200 сая ам.долларын төлбөрийг барагдуулсан бөгөөд үүнээс 281 сая ам.долларын төлбөрийг төрийн сангийн мөнгөн хөрөнгөөс төлсөн байна. Гадаад үнэт цаасны төлбөр 2026 оныг хүртэл байхгүй хэдий ч тус оноос эхлэн 5 жилийн хугацаанд эргэн төлөгдөх хуваарьтай 2.6 тэрбум ам.долларын дүн бүхий эргэн төлөлт хүлээгдэж байна.

Гадаад бондын эргэн төлөлтийн хуваарь




Мөнгөний нийлүүлэлт

2023 оны 11-р сард 35.4 их наяд төгрөг байсан мөнгөний нийлүүлэлт 2024 оны 11-р сард 41.5 их наяд төгрөгт хүрч, 6.1 их наяд төгрөгөөр өссөн байна.




Монголбанкны Мөнгөний бодлогын хороо 2024 оны 12-р сарын 12, 13-нд хуралдаж, бодлогын хүүг 10 хувьд хэвээр хадгалах шийдвэр гаргасан байна. Мөн банкны төгрөгийн болон гадаад валютын заавал байлгах нөөцийн хувь хэмжээг 1 нэгж хувиар нэмэгдүүлэхээр шийдвэрлэжээ. Дотоодын эдийн засгийн нөхцөл байдлын хувьд, зээлийн өсөлт эрчимжиж байгаа нь хэрэглээний импорт, дотоод эрэлтийг өдөөх, цаашлаад санхүүгийн салбарт эрсдэл хуримтлагдахад хүргэж болзошгүй тул Монголбанкнаас мөнгөний бодлогын хүүг 10 хувьд хадгалах, заавал байлгах нөөцийн хувь хэмжээг нэмэгдүүлэх замаар эдийн засгийн тогтвортой байдлыг хангах арга хэмжээ авч байна.

2024 оны III улирлын байдлаарх нийт зээл/цэвэр/ 33.3 их наяд буюу өмнөх онтой харьцуулахад 27.6 хувиар өссөн байна.



2024 оны II улирлын байдлаарх шинээр иргэдэд олгосон зээлийн хэмжээ 36% нэмэгдэв.



2024 оны II улирлын байдлаарх шинээр бизнесүүдэд олгосон зээлийн хэмжээ 61% нэмэгдэв.


Боловсруулах, барилга болон худалдааны салбарт олгосон зээлийн хэмжээ 50%-иар нэмэгдсэн байна.



Банк санхүүгийн зах зээл


Банкны салбарын нийт эх үүсвэр өмнөх оны 2-р улиралтай харьцуулахад 8.4 их наяд төгрөгөөр нэмэгдсэн байна.

Банкнудын харилцах хадгаламжийн дүн II улирал их наяд ₮



Банкнудын эх үүсвэр 29% нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Монголын банкны системийн эх үүсвэрийн хэмжээ тогтвортой өсөж, санхүүгийн салбарын хөгжил, хөрөнгө төвлөрөл нэмэгдэж байна.

Банкуудын өөрийн хөрөнгийн өгөөж, жил бүрийн II улирал (хувиар)




Системийн нөлөө бүхий Монголын 5 банкны өөрийн хөрөнгийн харьцаа 16%-ийн дундаж үзүүлэлт нь энэ шаардлагаас давж гарсан тул санхүүгийн тогтвортой байдлыг хангаж байна.

Банкны салбарын чанаргүй зээлийн хэмжээ буурч сүүлийн жилүүдэд байгаагүй доод хэмжээндээ ирлээ. Салбарын хэмжээнд чанаргүй зээл 5.9% байна.

Эдийн засгийн салбаруудын сэргэлт, голчлон уул уурхай, боловсруулах болон барилгын салбарын сэргэлт нь зээлийн чанарт эерэгээр нөлөөлсөн байна.

Бизнесийн чанаргүй зээлийн харьцаа, жил бүрийн II улирал (хувиар)




Иргэдийн чанаргүй зээлийн харьцаа, жил бүрийн II улирал (хувиар)




Хөрөнгийн зах зээл

Зах зээлийн үнэлгээ болон арилжааны хэмжээ: 2024 оны туршид Монголын хөрөнгийн зах зээл тогтвортой өсөлт үзүүлж, III улиралд зах зээлийн үнэлгээ 12.1 их наяд төгрөгт хүрч, арилжааны хэмжээ 1.058 их наяд төгрөгт хүрсэн нь хөрөнгө оруулагчдын сонирхол нэмэгдэж байгааг илтгэнэ. Хөрвөх чадвар бага түвшинд буюу 1.8%-тай байна. Мөн нийт арилжааны 36 хувийг бондын зах зээл эзэлсэн байна.




Хөрөнгө оруулагчдын арилжаанд эзлэх хувь: Арилжаанд оролцогчдын 54.6 хувийг Дотоодын иргэн, 43.7 хувийг Дотоодын ААН-ийн хийсэн гүйлгээ эзэлж байна.



эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Биржийн бус зах зээл үүссэн цагаас хойш 2024 оны 3-р улирал хүртэл нийт 127 компани амжилттай хөрөнгө оруулалт татжээ. 2024 оны 12 дүгээр сарын 17-ны өдрийн байдлаар нийт 3.0 их наяд төгрөгийн арилжаа хийгдсэн бөгөөд үүний 1.9 их наяд төгрөг нь анхдагч арилжаа бүрдүүлжээ.



Бондын зах зээлийн хувьд 2024 онд түүхэн жил байлаа. Учир нь 2024 оны 06 дугаар сард Монгол Улсын анхны орон нутгийн бонд болох “Улаанбаатар бонд” гарч 500 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүлсэн. Мөн Монголын хөрөнгийн зах зээлд ногоон бондууд амжилттай хөрөнгө татан төвлөрүүлсэн. Үүнд

- Хаан банк: 2024 онд 25 сая ам.долларын ногоон бондын санхүүжилт амжилттай татан төвлөрүүлсэн.
- Худалдаа хөгжлийн банк: 2024 онд 300 сая ам.долларын бонд гаргасан бөгөөд үүний тодорхой хэсэг нь ногоон төслүүдэд зориулагдсан.
- 2024 онд анх удаа аж ахуйн нэгжийн төлөөлөл болж TML Plastics компани ногоон бонд гаргасан.
- Төрийн банк нь 2024 оны 12-р сард дотоодын биржийн бус зах зээлд 10 тэрбум төгрөгийн "Ногоон ирээдүй" бондыг амжилттай гаргасан.

Дүгнэлт

2024 оны эхний хагас жилд Монгол Улсын эдийн засаг 5.6%-ийн өсөлттэй байсан бол гуравдугаар улирлын байдлаар эдийн засгийн өсөлт 3.9%-д хүрч, оны эхний гурван улирлын нийлбэрээр 5%-ийн өсөлттэй гарсан байна.

Эдийн засгийн өсөлт: Монгол Улсын эдийн засаг 2024 онд 5%-иар өссөн нь харьцангуй сайн үзүүлэлт юм. Уул уурхай, барилга, тээвэр зэрэг салбарууд өсөлтөд түлхэц үзүүлж байна.

Инфляци: 2024 оны 11-р сарын байдлаар инфляцийн түвшин 8.1%-д хүрч, үүнийг удаан хугацаагаар тогтворжуулах шаардлагатай байгааг харуулж байна.

Валютын нөөц: Монгол Улсын валютын нөөц 2024 оны эцэс гэхэд 5 тэрбум ам.долларт хүрэх хүлээлттэй байгаа нь эдийн засгийн тогтвортой байдлыг хангахад чухал үүрэг гүйцэтгэж байна.

2024 оны төсөв 1.3 их наяд төгрөгийн ашигтай гарч, хөгжлийн сан руу хөрөнгө оруулах боломж бүрдэж байна. Энэ нь Монгол Улсын урт хугацааны эдийн засгийн тогтвортой хөгжлийн нэг чухал үзүүлэлт юм.

Монгол Улсын эдийн засаг нь өсөлттэй, гадаад худалдааны өргөжилт, экспортын амжилттай байгаа хэдий ч инфляци, болон валютын нөөцийн асуудалд анхаарах шаардлагатай байна. Тогтвортой хөгжлийг хангахын тулд эдийн засгийн бүтэц, салбаруудыг олон улсын стандартад нийцүүлэн өөрчлөх шаардлага байгаа юм.

Хөдөлмөрийн зах зээл: Эдийн засгийн өсөлтийн нөлөөгөөр хөдөлмөрийн зах зээл идэвхжиж 2024 оны 3 дугаар улиралд ажилчдын тоо 1 сая 360 мянгад, ажиллах хүчний оролцооны түвшин 63.0 хувьд хүрсэн үзүүлэлттэй байна.

Уул уурхай: Зэс, алтны дэлхийн зах зээлийн үнэ өсөх хүлээлттэй байгаа тул уул уурхайн компаниудын хувьцааны үнэ тогтвортой өсөх магадлалтай. Оюу Толгой төслийн далд уурхайн олборлолт бүрэн хүчин чадлаараа ажиллаж эхэлнэ.

Хөрөнгийн зах зээл: 2024 онд Монголын Хөрөнгийн Биржийн индексүүд болох MSE-A, MSE-B, TOP-20 нь бүгд өссөн ногоон жил болон өндөрлөж байна. TOP 20 2021 оны 9 дүгээр сард бүх цагийн дээд ханш болох 49,252-д хүрсэн бол энэ оны 8 дугаар сард 50,741 хүрсэн нь Монголын хөрөнгийн зах зээлийн уналтад цэг тавьжээ.